



**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ**

**МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙН
ЗАРИМ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ГҮЙЦЭТГЭСЭН ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС
ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2026 он**

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГҮЙЦЭТГЭСЭН ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр баталсан удирдамжийн хүрээнд Монголын үндэсний музейгээс 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр ирүүлсэн “Зөрчил шалгуулах тухай” 241 дүгээр албан бичиг, музейн ажилтан Г.Хос-Эрдэнийн 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдад гаргасан гомдолд дурдагдсан асуудлаар дотоод хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах зорилгоор шалгалтыг гүйцэтгэлээ.

Ажлын хэсгийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Түмэндэмбэрэл ахалж, тус газрын ахлах шинжээч Ц.Алтанхуяг, дотоод аудитор Г.Шүрэндолгор, гэрээт ажилтан О.Пүрэвсүх нар ажиллалаа.

Батлагдсан удирдамжийн “Хяналт шалгалтын хамрах хүрээ, чиглэл” гэсэн хэсэгт заасны дагуу Монголын Үндэсний музей /цаашид МҮМ гэх/-н Эрдэм шинжилгээ, судалгааны төв /цаашид ЭШМТ гэх /-өөс гүйцэтгэсэн 5 удаагийн авран хамгаалах судалгааны ажлуудыг гүйцэтгэх гэрээ, тайлан, төсөв, хөрөнгийн зарцуулалтын санхүүгийн анхан шатны баримт, материалыг хянаж, мөн ажилтан Г.Хос-Эрдэнийн мэдүүлсэн гомдолд дурдсан 2 асуудлаар дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн болно. Үүнд:

- Дундговь аймгийн Өндөршил сумын Жаргалант нэртэй XV-48000101 дугаар 377.22 га талбайд угсаатны зүйн авран хамгаалах судалгааны төсвийн зарцуулалт;
- Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт орших Цагаан чулуут нэртэй MV-004646 тусгай зөвшөөрлийн 32,97 га талбайд угсаатны зүйн авран хамгаалах судалгааг төсвийн зарцуулалт;
- Иргэн Г.Хос-Эрдэний гомдолд дурдсан музейн албан хаагчдыг Хайнаньд амруулахад зарцуулсан зардлын зарцуулалт;
- Мөн Г.Хос-Эрдэний гомдолд дурдсан Монголын үндэсний музейн албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан нэрийдлээр мөнгө шамшигдуулсан гэх асуудал болно.

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ТОГТООГДСОН БОДИТ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. МҮМ-н захирлын 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтэд ““Харвайн толгой” ХХК-д Дундговь аймгийн Өндөршил сумын Жаргалант нэртэй XV-48000101 дугаар 377.22 га талбайд угсаатны зүйн авран хамгаалах судалгаа хийсэн дүгнэлт хүргүүлсэн байтал тус талбайд судалгаа хийх гэрээг “Эм Эн Эн Си” ХХК-тай байгуулсан байна. Түүнчлэн авран хамгаалах ажлын томилолт, удирдамжийн агуулга алдаатай ба хянасан хэмээн ЭШСТ-ийн дарга Ч.Баяндэлгэрийн гарын үсгийг хуурамчаар зурсан, судалгааны баг бүрэлдэхүүн холбогдох журмыг зөрчсөн, өмнөх судалгааны дүгнэлтийг хуулбарласан зэрэг нөхцөл байдал илрээд байна” гэснийг нягтлан шалгахад:

- 1.1 Харвайн толгой ХХК-иас авран хамгаалах судалгаа хийлгэх тухай албан хүсэлт тус музейн бичиг хэрэгт бүртгэгдээгүй байна. Энэ нь МҮМ-н эрдэм шинжилгээний төвийн

- журмын “7.2.2 Судалгааны захиалгын саналыг албан бичгээр хүлээн авна” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй гэж дүгнэв.
- 1.2 МҮМ-н захирал Б.Сарантуяа “ЭМ ЭН ЭН СИ” ХХК-тай 2025 оны 04 дүгээр сарын 12-ний өдрийн №12 тоот дугаартай 377.22 га талбайд угсаатны зүйн судалгаа хийх ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байна. Гүйцэтгэгч талыг төлөөлж ЭША Г.Хос-Эрдэнэ гарын үсэг зурсан нь МҮМ-н эрдэм шинжилгээний төвийн журмын “7.2.4 Захиалгат судалгааг гүйцэтгэх шийдвэр гарсан тохиолдолд судалгааны ажил гүйцэтгэх гэрээ байгуулна. Гэрээг Төвийн дарга байгуулж, Музейн захирлын гарын үсэг, тамгаар баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.
 - 1.3 МҮМ-н захирлын 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/130 тушаалаар 2025 оны 09 дүгээр сарын 15-17-ны өдрийн хооронд 3 хоногийн хугацаатайгаар ЭША Г.Хос-Эрдэнэ, Г.Энхбаяр нарыг хээрийн судалгааны багт томилсон байна. Тушаалын хавсралтаар судалгааны ажлын удирдамжийг 3 хоног, томилолтын ажлын төсвийг 5 хоногоор тооцож 3,500.0 мянган төгрөгөөр баталж, томилолтын ажиллуулах хоног, томилолтын зардал олгох хоногийг зөрүүтэй баталсан байна.
 - 1.4 Тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан хээрийн шинжилгээний ангийн удирдамжийг хянасан албан тушаалтны нэр, гарын үсэг байхгүй зөвхөн удирдамж боловсруулсан ЭША Г.Хос-Эрдэнэ гэсэн гарын үсэгтэй байгаа нь МҮМ-н эрдэм шинжилгээний төвийн журмын “7.4.1 Судалгаа бүрд судалгааны зорилго, зорилт, арга зүй, бүрэлдэхүүн, хугацаа, хамрах хүрээ зэргийг тусгасан удирдамж, төлөвлөгөө боловсруулж Төвийн даргаар батлуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.
 - 1.5 Авран хамгаалах ажлын удирдамжийг хянасан хэмээн ЭШСТ-ийн дарга Ч.Баяндэлгэрийн гарын үсгийг хуурамчаар зурсан гэдгийг шалгах боломжгүй байна. Гарын үсгийг хуурамчаар зурсан эсэх асуудлыг Цагдаагийн байгууллага, Шүүх шинжилгээний байгууллага эцэслэн дүгнэж шийдвэрлэдэг тул энэ гомдлыг эдгээр байгууллагад хандан шийдвэрлүүлэх нь зүйтэй.
 - 1.6 МҮМ-н төрийн сангийн 100900034411 дугаар нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд “ЭМ ЭН ЭН СИ ХХК -ны археологийн судалгааны төлбөр” гэсэн утгатай 3,500.0 мянган төгрөгийн орлого 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдөр орж, захирлын А/130 тушаалыг үндэслэн 3,500.0 мянган төгрөгийн 5 удаагийн гүйлгээ гаргасан байна.
 - 1.7 Албан томилолтоор ажиллуулах тухай захирлын 2025 оны 130 дугаар тушаалд судалгааны багийг томилолтоор 3 хоногоор ажиллуулахаар шийдвэрлэсэн байхад ЭША Г.Хос-Эрдэнэ, Г.Энхбаяр нарт томилолтын зардлыг 5 хоногоор олгосон, томилолтын унааны түрээсийн зардлыг мөн 5 хоногоор олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам”-ын 2.4 дэх заалтыг зөрчиж, 360.0 мянган төгрөгийн албан томилолтын зардал, 700.0 мянган төгрөгийн автомашины түрээсийн зардлыг тус тус илүү олгосон байна.

Угсаатан зүйн авран хамгаалах судалгаа хийх ажлын төсвийн зарцуулалтын дүн:

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ тариф	Нийт дүн	Зарцуулсан	Зарцуулбал зохих	Зөрүү
1	Томилолт	Хүн /хоног	10	90.0	900.0	900.0	540.0	360.0
2	Автомашины түрээс	Машин /хоног	5	350.0	1,750.0	1,750.0	1,050.0	700.0
3	Шатахуун	л/км	220	3.5	770.0	770.0	770.0	-
4	Хангамжийн материал	багц	1	80.0	80.0	80.0	80.0	-
					3,500.0	3,500.0	2,440.0	1,060.0

- 1.8 МҮМ, ЭМ ЭН ЭН СИ ХХК-ны хооронд 2025 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулсан. Энэ гэрээнд “Дундговь аймгийн Өндөршил сумын нутаг

дахь Харвайн толгой ХХК-ийн түгээмэл тархацтай хайгуулын тусгай зөвшөөрөлтэй “Жаргалант” нэртэй XV-48000101 дугаартай 377.22 га талбайд угсаатны зүйн судалгаа хийлгэх байгууллага, түүнийг төлөөлж захирал Н.Наран-Эрдэнэ” гэж захиалагч талаас гэрээ байгуулсан байна. Авран хамгаалах судалгааны ажлын төлбөрийг ЭМ ЭН ЭН СИ ХХК төлж, ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байтал, судалгааны ажлын тайланг Харвайн толгой ХХК-ны нэр дээр гаргасан байна. Энэ нь “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний 2.1 “Гүйцэтгэгч нь ... гэрээт ажлыг гэрээнд заасан хугацаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад нийцүүлэн гүйцэтгэж холбогдох тайлан дүгнэлт буюу гэрээт ажлын үр дүнг **Захиалагчид** актаар хүлээлгэн өгөх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

- 1.9 “Дундговь аймгийн Өндөршил сумын Жаргалант нэртэй газарт орших Харвайн толгой ХХК-ний тусгай зөвшөөрөлтэй XV -48000101 дугаартай 377.22 га талбайд хийсэн угсаатны зүйн тандалт судалгаа”-ны тайлан, гүйцэтгэсэн ЭША Г.Хос-Эрдэнэ, Г.Энхбаяр гэсэн гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажуулсан 35 хуудас баримт шалгалтын ажлын хэсэгт гаргаж өгсөн болно.
- 1.10 Энэ судалгааны тайланг хянахад Соёлын сайд, БШУС-ын 2023 оны А/509, А/562 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх журам”-ын 7.1 Судалгааны ангийн удирдагч, ахлагч тухайн жилд багтаан ЭШ-ний болон авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажлын тайланг тус бүрээр бэлтгэж, байгууллагын удирдлагад хүлээлгэн өгнө. 7.3 Судалгааны ажлын тайланд тавих шаардлагын 7.3.8 судалгааны ангийн удирдагч, эрдэм шинжилгээний ахлагчаар гарын үсэг зуруулж баталгаажуулсан байх гэсэн заалтыг хангаагүй, мөн Музейн эрдэм шинжилгээний төвийн журмын 8.1.5 “Судалгааны тайланг эцсийн байдлаар Төвийн дарга хянаж, захиалагч болон холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.
- 1.11 Авран хамгаалах ажлын удирдамжийн агуулга алдаатай, өмнөх судалгааны дүгнэлтийг хуулбарласан гэсэн асуудлыг тухайн чиглэлийн эрдэм шинжилгээний судалгааны байгууллагаар дүгнэлт хийлгэх шаардлагатай гэж ажлын хэсэг үзсэн болно.
- 1.12 МҮМ-н захирал Б.Сарантуяагийн “Томилолтоор ажиллуулах тухай” 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/130 тушаалын 1 дүгээр хавсралтаар Угсаатны зүйн авран хамгаалах судалгааны ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлахдаа удирдагч томилоогүй, Хээрийн судалгааны багийн ахлагчаар эрдэм шинжилгээний ажилтны албан тушаалд 2 жил 10 сар ажилласан туршлагатай ЭША Г.Хос-Эрдэнийг томилсон байна. Энэ нь Соёлын сайд, БШУС-ын 2023 оны А/509, А/562 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх журам”-ын “4.1.Судалгааны анги нь эрдэм шинжилгээний байгууллагын захирлын тушаалаар томилсон удирдагч, эрдэм шинжилгээний ахлагчтай байна. 4.2.Удирдагч нь ... палентлоги, археологийн чиглэлээр 15-аас доошгүй жил ажилласан туршлагатай, доктор ба түүнээс дээш зэрэгтэй ... байна.” Мөн журмын “4.3. Эрдэм шинжилгээний ахлагч нь ... палентлоги, археологийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай, магистр ба түүнээс дээш зэрэгтэй ... байна” гэсэн шаардлагыг хангахгүй байна.

Хоёр. Мөн 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 179, 180 дугаар албан бичгээр “Тун да шун майнинг” ХХК-д Дундговь аймгийн Иххэт сумын нутагт орших Цагаанчулуут нэртэй MV-004646 тусгай зөвшөөрлийн 32.97 га талбайд Угсаатны авран хамгаалах судалгаа хийсэн дүгнэлт хүргүүлсэн байдаг. Тайлан болон санхүүгийн баримт байхгүй, археологийн судалгааны мэргэжлийн бус дүгнэлт болсон. Дээрх дүгнэлтүүдтэй холбогдох тушаал, тайлангууд нь Соёлын өвийг хамгаалах тухай

хуулийн 1.1, 21.2.2, 27.11 дэх хэсэг, Музейн тухай хуулийн 17.1.5, 17.1.6 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/156 тоот тушаалын хавсралтын 2.1.1, 3.1.8, 3.2.2 дахь заалт, Соёлын сайд, БШУС-ын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/509, А/562 дугаартай “Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх журам”-ын 4.3, 7.3 дахь заалтууд зөрчигдсөн байж болзошгүй нөхцөл байдал үүсээд байна” гэснийг нягтлан шалгахад:

- 2.1 Тун да шун майнинг ХХК-иас авран хамгаалах судалгаа хийлгэх тухай албан хүсэлт тус музейн бичиг хэрэгт бүртгэгдээгүй байна. Энэ нь МҮМ-н эрдэм шинжилгээний төвийн журмын 7.2.2 Судалгааны захиалгын саналыг албан бичгээр хүлээн авна гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй гэж дүгнэв.
- 2.2 МҮМ, Тун да шун майнинг ХХК-ны хооронд авран хамгаалах судалгааны “Ажил гүйцэтгэх гэрээ” цаасан баримтаар байхгүй боловч энэ судалгааны ажлыг гүйцэтгэх албан хаагчдыг томилолтоор ажиллуулах тухай МҮМ-н захирлын 2025 оны А/135 дугаар тушаалын үндэслэл хэсэгт “МҮМ, Тун да шун майнинг ХХК-тай 2025 оны 09 дүгээр сарын 4-ны өдрийн №08/04 тоот ажил гүйцэтгэх гэрээ”-нд үндэслэсэн байна.
- 2.3 МҮМ-н захирлын 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/135 дугаар тушаалаар *Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт орших MV-004646 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн 32.97 га талбайд “Археологи угсаатан зүйн авран хамгаалах судалгаа”-г 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 20-ны өдрүүдэд зохион байгуулахаар шийдвэрлэж, тушаалын хавсралтаар хээрийн судалгааны баг бүрэлдэхүүн, удирдамж, томилолтын зардлыг 3,500.0 мянган төгрөгөөр баталсан байна.*
- 2.4 Монголын Үндэсний музейн төрийн сангийн 100900034411 дугаар нэмэлт дансанд “Зун Хуа Ин Си Куан” ХХК-ийн харилцах данснаас “Тун да шун майнинг ХХК угсаатны зүйн судалгаа хийлгэх” гэсэн утгатай 4,500.0 мянган төгрөгийн гүйлгээ 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр хийгдсэн байна.
- 2.5 Монголын Үндэсний музейн 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн “Дүгнэлт хүргүүлэх тухай” 179 болон 180 дугаар албан бичгээр Тун да шун Майнинг ХХК-нд “Дорноговь аймгийн Иххэт сумын нутагт орших Цагаанчулуут нэртэй MV-004646 тусгай зөвшөөрлийн 32.97 га талбайд угсаатны зүйн авран хамгаалах судалгааны ажлын дүгнэлт” хүргүүлсэн байна. Энэ албан бичигт судалгааны ажлын тайланг хавсралтаар хүргүүлсэн талаар дурдаагүй байна.
- 2.6 ЭША Г.Хос-Эрдэнээс энэ судалгааны ажилтай холбоотой асуудлыг тодруулахад “Авран хамгаалах судалгааны гэрээг байгуулж 1 хувийг тус компанид 1 хувийг байгууллагын санхүүгийн албанд өгсөн, томилолтоор ажиллуулах тушаал гарсан гэх боловч нягтлан бодогч захиалагч талаас холбогдох санхүүгийн баримт ирүүлээгүй гэсэн шалтгаанаар гүйлгээ хийгээгүй” гэж тайлбар өгсөн.
- 2.7 МҮМ-н Ерөнхий нягтлан бодогч Д.Мөнхзаяагаас энэ асуудлыг тодруулахад “Томилолтоор ажиллуулах тухай Захирлын 2025 оны А/135 дугаар тушаал, Тунда шун майнинг ХХК-тай байгуулсан гэрээ санхүүгийн албанд ирээгүй, судалгааны ажлыг гүйцэтгэх гүйлгээ хийгдээгүй” талаар бичгээр тайлбар өгсөн.
- 2.8 Хяналт шалгалтаар цуглуулсан баримтаас дүгнэхэд Тун да шун майнинг ХХК-тай байгуулсан 2025 оны 09 дүгээр сарын 4-ны өдрийн №08/04 тоот ажил гүйцэтгэх гэрээг үндэслэн МҮМ-н захирлын 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/135 дугаар “Томилолтоор ажиллуулах тухай” тушаал гаргасан боловч цаасан баримтаар байхгүй байна.
- 2.9 ЭША Г.Хос-эрдэнэ, Г.Энхбаяр нар Дорноговь аймгийн Их хэт сумын нутагт орших Тун да шун майнинг ХХК-ны хээрийн судалгааны ажилд томилолтоор ажиллуулах тухай тушаал гарсан өдөр буюу 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр МҮМ-н захирлын 179

дугаар албан бичгээр “Авран хамгаалах судалгааны дүгнэлт”, мөн өдрийн 180 дугаар албан бичгээр “Археологийн дүгнэлт” гаргаж Тун да шун майнинг ХХК-нд хүргүүлсэн байна. Эдгээр дүгнэлтийг гаргахдаа тухайн газарт албан томилолтоор ажиллаагүй, судалгааны тайлан бичээгүй нь Соёлын сайд, БШУС-ын 2023 оны А/509, А/562 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх журам”-ын 6.2 Судалгааны анги палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажлыг зөвшөөрлийн баримт бичигт заасан газарт, тогтоосон хугацаанд судалгааны арга зүйн дагуу гүйцэтгэнэ, 7.1 Судалгааны ангийн удирдагч, ахлагч тухайн жилд багтаан ЭШ-ний болон авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажлын тайланг тус бүрээр бэлтгэж, байгууллагын удирдлагад хүлээлгэн өгнө, мөн Музейн эрдэм шинжилгээний төвийн журмын 8.1.5 “Судалгааны тайланг эцсийн байдлаар Төвийн дарга хянаж, захиалагч болон холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

- 2.10 МҮМ-н захирал Б.Сарантуяагийн “Томилолтоор ажиллуулах тухай” 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/135 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар Угсаатны зүйн авран хамгаалах судалгааны ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлахдаа удирдагч томилоогүй, Хээрийн судалгааны багийн ахлагчаар эрдэм шинжилгээний ажилтны албан тушаалд 2 жил 10 сар ажилласан туршлагатай ЭША Г.Хос-Эрдэнийг томилсон байна. Энэ нь Соёлын сайд, БШУС-ын 2023 оны А/509, А/562 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх журам”-ын “4.1.Судалгааны анги нь эрдэм шинжилгээний байгууллагын захирлын тушаалаар томилсон удирдагч, эрдэм шинжилгээний ахлагчтай байна. 4.2.Удирдагч нь ... палентлоги, археологийн чиглэлээр 15-аас доошгүй жил ажилласан туршлагатай, доктор ба түүнээс дээш зэрэгтэй ... байна.” Мөн журмын “4.3. Эрдэм шинжилгээний ахлагч нь ... палентлоги, археологийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай, магистр ба түүнээс дээш зэрэгтэй ... байна” гэсэн шаардлагыг хангахгүй байна.
- 2.11 Тун да шун майнинг ХХК нь судалгааны ажлын төлбөрийг МҮМ-н нэмэлт санхүүжилтийн дансанд төлөөгүй, судалгааны ажил хийгдээгүй байхад ЭША Г.Хос-Эрдэнэ тус компанид 2 удаагийн үйлдлээр “Судалгаа, археологийн ажлын дүгнэлт” гарган өгч, төлбөрийг хувьдаа ашигласан байх магадлалтай тул Авлигын эсрэг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1- заасан “... албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй” -гэснийг үндэслэн дараагийн шатанд шилжүүлэв.

Гурав. Монголын Үндэсний музейн 2025 онд хэрэгжүүлсэн дээрх археологийн авран хамгаалах судалгаанаас бусад судалгааны ажлын гүйцэтгэлийг хянахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- 3.1. Дундговь аймгийн Өндөршил сумын нутагт орших “Цагаан” нэртэй 2046,05 га талбайд угсаатны зүйн тандалт судалгаа хийлгэхээр захиалагч байгууллага Мөнх баялаг майнинг ХХК 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр 34 дугаартай ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, тус компаниас 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр 4,500.0 мянган төгрөгийг музейн нэмэлт санхүүжилтийн дансанд төлсөн байна. МҮМ-н захирлын 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/95 дугаар тушаалаар судалгааны гүйцэтгэгчээр музейн ЭШСТ-ийн дарга Ч.Баяндэлгэр, ЭША Г.Хос-Эрдэнэ нарын 4 ажилтныг 2025 оны 07 дүгээр сарын 6-наас 11-ний өдрүүдэд ажиллуулахаар шийдвэрлэсэн байна. Энэ судалгааны ажлын томилолтын зардалд 4,500.0 мянган төгрөгийг баталж зарцуулсныг хянахад санхүүгийн анхан шатны баримт бүрдэл дутуу тухайлбал судалгааны ажлын тайлан, гэрээ дүгнэсэн акт, томилолтын зардлын тооцоо бодсон актгүй байна.

- 3.2. Дорноговь аймгийн Их хэт сумын нутагт орших “Хайтан” нэртэй 1205.14 га талбайд угсаатны зүйн тандалт судалгаа хийлгэхээр захиалагч байгууллага Зун хуа ин си куан ХХК -тай 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр №35 гэрээ байгуулж, тус компаниас 4,500 мянган төгрөгийг музейн нэмэлт санхүүжилтийн дансанд “Тун да шун майнинг ХХК угсаатны зүйн судалгаа хийлгэх” гэсэн гүйлгээний утга бичиж төлсөн байна. МҮМ-н захирлын 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/94 дүгээр тушаалаар уг судалгааны гүйцэтгэгчээр музейн ЭШСТ-ийн дарга Ч.Баяндэлгэр, ЭША Г.Хос-Эрдэнэ нарын 4 ажилтныг 2025 оны 07 дүгээр сарын 12-оос 17-ны өдрүүдэд ажиллуулахаар шийдвэрлэж, 4,500 мянган төгрөгийн төсөв баталсан байна. Энэ судалгааны ажлын санхүүгийн анхан шатны баримт бүрдэл дутуу тухайлбал судалгааны ажлын гэрээ дүгнэсэн акт, томилолтын зардлын тооцоо бодсон актгүй байна.
- 3.3. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших 1984.77 гектар талбайд угсаатны зүйн тандалт судалгаа хийлгэхээр захиалагч байгууллага Стандарт минералс ХХК 2025 оны 05 дугаар сарын 21-ны өдөр 3,377.0 мянган төгрөгийг музейн нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн байна. МҮМ, Стандарт минералс ХХК-ны хооронд 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр 01 дугаартай ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, захирлын 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/96 дугаар тушаалаар судалгааны гүйцэтгэгчээр музейн ЭШСТ-ийн дарга Ч.Баяндэлгэр, ЭША Г.Хос-Эрдэнэ нарыг 2025 оны 07 дүгээр сарын 18-аас 23-ны өдрүүдэд ажиллуулахаар шийдвэрлэсэн байна. Энэ судалгааны ажлын томилолтын зардалд 3,150.0 мянган төгрөгийг баталж зарцуулсныг хянахад санхүүгийн анхан шатны баримт бүрдэл дутуу тухайлбал судалгааны ажлын тайлан, гэрээ дүгнэсэн акт, томилолтын зардлын тооцоо бодсон актгүй байна.
- 3.4. Өмнөговь аймгийн Цогт-Цэций сумын Сийрст багт байрлалтай БМБТ-ын 20 га нутаг дэвсгэрт тандалт судалгааны ажил хийлгэхээр 2025 оны 09 дүгээр сарын 11-ны өдөр 304-5225 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж 2025 оны 09 дүгээр сарын 15-20 өдрүүдэд угсаатны зүйн авран хамгаалах судалгааны ажлыг музейн ЭША Г.Хос-Эрдэнэ, Г.Энхбаяр нарын бүрэлдэхүүнтэй ажиллаж судалгааны тайланг гаргасан байна. Тус судалгаатай холбоотой санхүүгийн анхан шатны баримтыг үзэхэд захиалагч байгууллагын албан хүсэлт, томилолтоор ажиллуулах тухай тушаал гаргаагүй, хээрийн судалгааны удирдамж батлаагүй зэрэг зөрчилтэй байна.
- 3.5. МҮМ-н Эрдэм шинжилгээ төвийн ЭША Г.Хос-Эрдэнэ нь эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр 3 жил ажилласан туршлагатай байна. Гэтэл түүнийг захирлын 2025 оны 130, 135 дугаар тушаалд судалгааны багийн ахлагчаар томилсон нь Соёлын сайд, БШУС-ын 2023 оны А/509, А/562 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх журам”-ын 4.3-д заасан “Эрдэм шинжилгээний ахлагч нь судалгааны ангийн өдөр тутмын судалгааны ажлыг чиглүүлэн зохион байгуулж ажиллах үндсэн үүрэгтэй байх бөгөөд Монгол Улсын иргэн, палеонтологи, археологийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай магистр ба түүнээс дээш зэрэгтэй, тухайн байгууллагын орон тооны ажилтан байна” гэсэн заалттай бүрэн нийцэхгүй байна.
- 3.6. Угсаатан зүй, соёлын биет бус өвийн авран хамгаалах судалгааны ажлыг гүйцэтгүүлэх тухай захиалагчийн албан хүсэлт ирүүлээгүй, Мак цемент ХХК-ийн захиалгат ажлыг гүйцэтгүүлэх тухай тушаал батлуулаагүй, гэрээ дүгнээгүй, албан томилолтын анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй зэрэг зөрчил нийтлэг илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2. “Батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад хяналт тавих”, 16.5.5. “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Дөрөв. ЭША Г.Хос-Эрдэнэ гомдолдоо “Манай байгууллагад тодорхойгүй асуудлууд оршсоор байна. Өнгөрсөн жилийн давсан орлого хэмээн ажилтнуудад тодорхой хэмжээний мөнгө олгосон боловч та бүхний эв нэгдлийн төлөө Хайнаньд амруулахаар боллоо гэж хуучин захирал Б.Сарантуяа нь захиргааны зөвлөлийн гишүүдтэй зөвшилцөн гарсан шийдвэр гэж 2 дугаар сард явж амарсан. Тэгэхдээ нэг ажилтанд 3 сая төгрөг орсон гэж үзвэл явсан ч яваагүй зардлын мөнгө гэж хүн бүрээс 1.5 сая төгрөг бэлнээр гаргуулан авсан. Үлдсэн зардлыг бид гаргах болно гэсэн боловч хэдэн төгрөг зарлагдсан нь тодорхойгүй, яваагүй хүний мөнгийг өгөөгүй. Ажилтнуудаас мөнгө татсан байж бартераар явсан, аялал жуулчлалын компанидаа өртэй гэх яриа гарсныг захиргааны гишүүд нуун дарагдуулж байх магадлалтай. 50 гаруй сая төгрөгийн өртэй гэх. Ер нь төсвийн байгууллага Төрийн сангаар дамжуулан зарлага гаргах ёстой гэтэл дээрх тохиолдолд маш их хэмжээний мөнгө бэлнээр гарсан нь хууль бус хэм үзэж байна” гэснийг нягтлан шалгахад:

- 4.1 МҮМ-н захирал Б.Сарантуяа “Нью Жуулчин тур” ХХК-ны гүйцэтгэх захирал Д.Наранцэцэг нар 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр 08/2025 дугаартай музейн ваучерын үйлчилгээний гэрээ байгуулсан. Энэ гэрээ нь Монгол Улсын түүх, соёлын дурсгалт үзмэрүүдийг дэглэн байршуулсан музейн байнгын үзэсгэлэнгийн үзүүлэг, танхимаар үзэгч жуулчдад музейн үйлчилгээг хүргэн ая тухай үйлчлэх, үйлчилгээний үнэ тарифын дагуу төлбөрийг барагдуулахтай холбогдох харилцааг зохицуулах зорилготой.
- 4.2 Гэрээний 2.1.7 -д “Музейн санхүүгээс үйлчилгээний төлбөр тооцоог хянаж сар бүрийн 25-ны дотор төлбөрийн нэхэмжлэлийг захиалагчид цахим шуудангаар илгээх бөгөөд талууд улирал тутамд тооцоо нийлсэн акт үйлдэж, төлбөрийг ажлын 5 хоногийн дотор музейн нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлнэ” гэж тохиролцсон байна.
- 4.3 Гэрээний 7.5-д талууд энэхүү гэрээг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдуулан мөнгөн буюу мөнгөн бус хэлбэрээр шагнал, шан харамж, урамшуулал зэрэг гэрээнд тусгагдаагүй аливаа төлбөрийг харилцан төлөөгүй болно гэж заасан.
- 4.4 Гэрээний дээрх заалтуудаас дүгнэхэд музейн үйлчилгээний төлбөрийг бартераар тооцон барагдуулах тухай заалт байхгүй, гэрээнд тусгагдаагүй хэлбэрээр үйлчилгээний төлбөрийг барагдуулахгүй талаар тохиролцсон байна.
- 4.5 МҮМ-н захирал Б.Сарантуяа Нью Жуулчин тур ХХК-ны гүйцэтгэх захирал Д.Наранцэцэг нар 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр ОУТ/СҮХ/250212-40 дугаартай “Аялал жуулчлалын гэрээ” байгуулсан байна.
- 4.6 Гэрээний 1.1-д аялал зохион байгуулагч нь захиалагчийн хүсэлтээр БНХАУ-ын Саньяа хотын шууд нислэгтэй 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрөөс 19 -ны өдөр хооронд 7 шөнө 7 өдрийн аялалд 40 хүний үйлчилгээ зохион байгуулах, захиалагч гэрээний нөхцөлийн дагуу аяллын төлбөрийг төлөх харилцааг зохицуулах гэж заасан.
- 4.7 Гэрээний 5.1-д аялалд оролцох 40 хүний аяллын төлбөр нийт 141,900.0 мянган төгрөгөөр тохиролцсон. Үүнээс 2024 оны хоорондын тооцоо болон бэлэн төлбөрөөс 49,580.0 мянган төгрөгийг хасаж 92,320.0 мянган төгрөгийг 2025 оны 11 сарын 15-ны өдөр хүртэл байгууллага хоорондын үйлчилгээний төлбөрөөс хасахаар харилцан бартераар тохиролцов гэжээ.
- 4.8 Аяллын төлбөр тооцоог хариуцсан тус музейд ажиллаж байсан ерөнхий нягтлан бодогч Д.Батцэцэгээс тодруулга авахад “Аялалд хамрагдсан 31 албан хаагч тус бүрээс 1,500.0 мянган төгрөгийг, бусад гадны аялагч 9 хүн бүрээс 3,300.0 мянган төгрөгийг бэлнээр хурааж авсан, аяллын төлбөрөөс гадна өглөө, оройн хоолонд хэрэглэсэн” гэж утсаар тайлбар өгсөн. Гэтэл Аялал жуулчлалын гэрээний хавсралтаар баталсан “Аяллын хөтөлбөр”-т зааснаар өглөө, оройн хоолны үнэ багтсан байна.

- 4.9 Аялалд оролцсон 40 хүнээс нийт 76,200.0 мянган төгрөгийг бэлнээр хураан авч, Нью жуулчин тур ХХК -нд 49,580.0 мянган төгрөгийн төлж, үлдэгдэл 26,620.0 мянган төгрөгийг аялагчдын хоол, бусад зардалд зарцуулсан гэх боловч тайлан тооцоог хамт олонд танилцуулаагүй байна.
- 4.10 “Аялал жуулчлалын гэрээ”-ний 5.1-д заасан 92,320.0 мянган төгрөгийн бартерын төлбөрөөс 2025 оны 02 дугаар сараас 10 дугаар сар хүртэлх хугацаанд музейн үзмэр, үзүүлэг үзсэн Нью жуулчин тур ХХК-ийн 1663 жуулчны тасалбарын үнэ 33,260.0 мянган төгрөгийг хоорондын тооцоогоор хааж 59,060.0 мянган төгрөгийн үлдэгдэл тооцоотой байна.
- 4.11 Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын 33,260.0 мянган төгрөгийг харилцах дансанд төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд бүртгэж тайлагнаагүй, хамт олны хувийн гадаад аялал жуулчлалын зардалд зарцуулсан өр төлбөрт хаасан үйлдэл нь Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 “... үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг дараах арга хэмжээнд зарцуулахыг хориглоно. 46.5.3 ... гадаад томилолтын зардлыг санхүүжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ 14.4.5 бүх орлого, 14.4.6 бүх зардал, Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 6.1 Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого, түүний зарцуулалтыг сар, улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн байдлын тайлан, орлого, зарлагын явцын мэдээнд оруулж, тухайн тайлант оны санхүүгийн болон үр дүнгийн тайланд тусгана” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Тав. ЭША Г.Хос-Эрдэнэ гомдолдоо “Өнгөрсөн жилийн 10 дугаар сараас Сонгдо, Интермэд, Сөүл эмнэлэгт эмнэлгийн үзлэгт хамруулна гэж ажилтнуудаас санал авч байсан боловч шийдэгдэхгүй байсаар 2025 он гарсан. Энэ тухай ажилтнуудыг асуухад дэндүү үнэтэй, бага зардлаар үзэх эмнэлэг судалж байна гэсэн хариу өгч байсан. Гэвч ажилтнуудыг эмнэлэгт үзүүлсэн хэмээн зарлагадан мөнгийг шамшигдуулсан гэх яриа ч ажилтнуудын дунд үүсэж, бидний хөдөлмөрийг зарим нэг нь хувьдаа ашиглаж байна гэж бухимдалтай байна” гэснийг нягтлан шалгахад:

5.1 Монголын үндэсний музейн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Энхбат дараах нэр бүхий 3 компанитай ажилтны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх багц шинжилгээ хийх, үйлчилгээ үзүүлэх 57,744.0 мянган төгрөгийн үнэ бүхий гэрээг байгуулсан. Үүнд:

- Дархан детект ХХК-тай 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 02/39 дугаартай 19,850.0 мянган төгрөгийн гэрээ;
- Таван богд солишнс ХХК-тай 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр 02/41 дугаартай 18,620.0 мянган төгрөгийн гэрээ;
- Сөүл сэниорс товер ХХК-тай 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 24/32 дугаартай Улаанбаатар сонгдо эмнэлгийн багц шинжилгээ хийлгэх тухай 19,274.0 мянган төгрөгийн гэрээ.

5.2.МҮМ-н 2024, 2025 оны харилцах дансны хуулга, санхүүгийн баримтыг шалгахад гэрээ байгуулсан дээрх 3 байгууллагад эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний төлбөр шилжүүлээгүй байна. Иймд эрүүл мэндийн үзлэгийн төлбөрийг зориулалт бусаар зарцуулсан тухай асуудал нотлогдоогүй болно.

Зургаа. ЭША Г.Хос-Эрдэнэ гомдолдоо МҮМ-н захирлын 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн А/120 дугаар тушаалын дагуу Хэнтий аймгийн Дэлгэрхаан, Баянмөнх сумдын зааг нутагт Гүн бүрд нуурын ёроолд археологийн хайгуул судалгааны ажил гүйцэтгэх зардалд зарцуулсан 18,202.1 мянган төгрөгийг зориулалт бусаар ашигласан тухай асуудлыг дурдсан.

Гомдолд дурдагдсан энэ асуудлыг Авлигатай тэмцэх газарт шалгагдаж байгаа тул Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7. “Хяналт шалгалтыг давхардуулахгүй бөгөөд төрийн эрх бүхий байгууллагаас хийсэн шинжилгээний дүн, дүгнэлтийг хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага харилцан хүлээн зөвшөөрөх” гэсэн заалтын дагуу энэ шалгалтаар давхардуулан шалгах боломжгүй байна.

ДҮГНЭЛТ

Ажлын хэсгээс удирдамжид заасны дагуу гомдол гаргагч 2 талаас хөндсөн Монголын Үндэсний музейн угсаатан зүйн судалгааны ажлыг гүйцэтгэх үе шат бүрийн захиргааны баримт бичгийг боловсруулсан, хянасан албан хаагчдын хууль тогтоомжоор хүлээсэн эрх, үүргийн хэрэгжилт, судалгааны ажлын албан томилолтын зардал, мөн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого, түүний зарцуулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгаж дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Харвайн толгой ХХК, Тун да шин майнинг ХХК зэрэг нийт 6 компаниас авран хамгаалах судалгаа хийлгэх тухай албан хүсэлт ирүүлээгүй байхад судалгааны ажлыг гүйцэтгэж байгаа нь МҮМ-н эрдэм шинжилгээний төвийн журмын 7.2.2 Судалгааны захиалгын саналыг албан бичгээр хүлээн авна гэсэн заалтыг зөрчсөн;
2. Угсаатан зүйн судалгаа хийх ажил гүйцэтгэх гэрээ байгуулахдаа гүйцэтгэгч талыг төлөөлж ЭША Г.Хос-Эрдэнэ гарын үсэг зурсан нь *МҮМ-н эрдэм шинжилгээний төвийн журмын 7.2.4 ... гэрээг Төвийн дарга байгуулж, Музейн захирлын гарын үсэг, тамгаар баталгаажуулна* гэсэн заалтыг зөрчсөн;
3. Судалгааны ажлын томилолтоор ажиллуулах тухай тушаалын хавсралтаар баталсан хээрийн шинжилгээний ангийн удирдамжийг хянасан албан тушаалтны нэр, гарын үсэг байхгүй зөвхөн удирдамж боловсруулсан ЭША Г.Хос-Эрдэнэ гэсэн гарын үсэгтэй байгаа нь *МҮМ-н эрдэм шинжилгээний төвийн журмын 7.4.1 Судалгаа бүрд судалгааны зорилго, зорилт, арга зүй, бүрэлдэхүүн, хугацаа, хамрах хүрээ зэргийг тусгасан удирдамж, төлөвлөгөө боловсруулж Төвийн даргаар батлуулна* гэсэн заалтыг зөрчсөн;
4. Авран хамгаалах судалгааны ажлын төлбөрийг ЭМ ЭН ЭН СИ ХХК төлж, ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байтал, судалгааны ажлын тайланг Харвайн толгой ХХК-ны нэр дээр гаргасан нь “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний 2.1 “Гүйцэтгэгч нь ... гэрээт ажлыг гэрээнд заасан хугацаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад нийцүүлэн гүйцэтгэж холбогдох тайлан дүгнэлт буюу гэрээт ажлын үр дүнг **Захиалагчид** актаар хүлээлгэн өгөх” гэсэн заалттай нийцээгүй;
5. ЭША Г.Хос-эрдэнийн гүйцэтгэсэн Харвайн толгой ХХК-ийн захиалсан судалгааны тайлан нь Соёлын сайд, БШУС-ын 2023 оны А/509, А/562 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх журам”-ын 7.1 Судалгааны ангийн удирдагч, ахлагч тухайн жилд багтаан ЭШ-ний болон авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажлын тайланг тус бүрээр бэлтгэж, байгууллагын удирдлагад хүлээлгэн өгнө. 7.3 Судалгааны ажлын тайланд тавих шаардлагын 7.3.8 судалгааны ангийн удирдагч, эрдэм шинжилгээний ахлагчаар гарын үсэг зуруулж баталгаажуулсан байх гэсэн заалтыг хангаагүй, мөн Музейн эрдэм шинжилгээний төвийн журмын 8.1.5 “Судалгааны тайланг эцсийн байдлаар Төвийн дарга хянаж, захиалагч болон холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулна” гэсэн заалтыг зөрчсөн;
6. Тун да шун майнинг ХХК-нд МҮМ-н захиралын 2025 оны 179 болон 180 дугаар албан бичгээр дүгнэлтийг гаргахдаа тухайн газарт албан томилолтоор ажиллаагүй, судалгааны тайлан бичээгүй нь Соёлын сайд, БШУС-ын 2023 оны А/509, А/562

- дугаар хамтарсан тушаалаар баталсан “Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх журам”-ын 6.2 Судалгааны анги палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгааны ажлыг зөвшөөрлийн баримт бичигт заасан газарт, тогтоосон хугацаанд судалгааны арга зүйн дагуу гүйцэтгэнэ, 7.1 Судалгааны ангийн удирдагч, ахлагч тухайн жилд багтаан ЭШ-ний болон авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажлын тайланг тус бүрээр бэлтгэж, байгууллагын удирдлагад хүлээлгэн өгнө, мөн Музейн эрдэм шинжилгээний төвийн журмын 8.1.5 “Судалгааны тайланг эцсийн байдлаар Төвийн дарга хянаж, захиалагч болон холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулна” гэсэн заалтыг зөрчсөн;
7. Тун да шун майнинг ХХК нь судалгааны ажлын төлбөрийг МҮМ-н нэмэлт санхүүжилтийн дансанд төлөөгүй, судалгааны ажил хийгдээгүй байхад ЭША Г.Хос-Эрдэнэ тус компанид 2 удаагийн үйлдлээр “Судалгаа, археологийн ажлын дүгнэлт” гарган өгч, төлбөрийг зориулалт бусаар ашигласан байх магадлалтай тул Авлигын эсрэг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1- заасан “... албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй” -гэснийг үндэслэн шилжүүлэв;
 8. ЭША Г.Хос-Эрдэнэ эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр 2 жил 10 сар ажилласан туршлагатай байхад судалгааны ажлын ахлагчаар 2 удаа томилсон 2025 оны 130, 135 дугаар тушаал гаргасан нь Соёлын сайд, БШУС-ын 2023 оны А/509, А/562 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх журам”-ын 4.3-д заасан “Эрдэм шинжилгээний ахлагч нь судалгааны ангийн өдөр тутмын судалгааны ажлыг чиглүүлэн зохион байгуулж ажиллах үндсэн үүрэгтэй байх бөгөөд Монгол Улсын иргэн, палеонтологи, археологийн чиглэлээр **10-аас доошгүй** жил ажилласан туршлагатай магистр ба түүнээс дээш зэрэгтэй, тухайн байгууллагын орон тооны ажилтан байна” гэсэн заалттай бүрэн нийцээгүй;
 9. Угсаатан зүй, соёлын биет бус өвийн авран хамгаалах судалгааны ажлыг гүйцэтгүүлэх 6 удаагийн ажлын баримтын бүрдлийг шалгахад тухайн захиалагч албан хүсэлт ирүүлээгүй, гэрээ дүгнээгүй, албан томилолтын анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй, мөн Мак цемент ХХК-ийн захиалгат ажлыг гүйцэтгэх тушаалыг батлаагүй зэрэг зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2. *“Батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад хяналт тавих”*, 16.5.5. *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”*, 13.7. *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”* гэсэн заалтуудыг зөрчсөн;
 10. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогын 33,260.0 мянган төгрөгийг харилцах дансанд төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд бүртгэж тайлагнаагүй, хамт олны хувийн гадаад аялал жуулчлалын зардалд зарцуулсан өр төлбөрт хаасан үйлдэл нь Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 *“... үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг дараах арга хэмжээнд зарцуулахыг хориглоно. 46.5.3 ... гадаад томилолтын зардлыг санхүүжүүлэх”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 *нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ 14.4.5 бүх орлого, 14.4.6 бүх зардал, Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан “ Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 6.1 Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт*

орлого, түүний зарцуулалтыг сар, улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн байдлын тайлан, орлого, зарлагын явцын мэдээнд оруулж, тухайн тайлант оны санхүүгийн болон үр дүнгийн тайланд тусгана” гэсэн заалтуудыг зөрчсөн;

11. Музейн 2024, 2025 оны харилцах дансны хуулга, санхүүгийн баримтыг шалгахад гэрээ байгуулсан дээрх 3 байгууллагад эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний төлбөр шилжүүлээгүй тул эрүүл мэндийн үзлэгийн төлбөрийг зориулалт бусаар зарцуулсан тухай асуудал нотлогдоогүй;
12. МҮМ-н захирлын 2025 оны А/120 дугаар тушаалын дагуу гүйцэтгэсэн археологийн хайгуул судалгааны ажлын 18,202.1 мянган төгрөгийг зориулалт бусаар ашигласан асуудлыг Авлигатай тэмцэх газарт шалгагдаж байгаа тул Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалтын дагуу энэ шалгалтаар давхардуулан шалгах боломжгүй байна.
13. Хууль тогтоомж, тушаал шийдвэр, Албан тушаалын тодорхойлолт, Хөдөлмөрийн гэрээг мөрдөж ажиллаагүй буруутай албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлтэй.

ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ

Дотоод хяналт шалгалтаар илэрсэн алдаа дутагдал, зөрчилд үндэслэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор холбогдох нэгжийн удирдлага, албан тушаалтанд дараах зөвлөмжийг хүргүүлэв. Үүнд:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт:

1. Соёлын сайд, БШУС-ын 2023 оны А/509, А/562 дугаар хамтарсан тушаалаар баталсан журмын 7.4 дэх заалтын дагуу гүйцэтгэсэн судалгааны ажлын тайланд хөндлөнгийн шинжээчээр дүгнэлт гаргуулдаг байх;
2. Мөн журмын 7.6-т заасны дагуу тухайн жилд гүйцэтгэсэн палентлоги, археологийн хайгуул, малтлага судалгааны ажлын тайланд мэргэжлийн зөвлөлөөр нэгдсэн дүгнэлт гаргуулдаг байх;
3. Мөн журмын 7.7-т заасны дагуу тухай жилд гүйцэтгэсэн палентлоги, археологийн хайгуул, малтлага судалгааны ажлын тайланг нэгдсэн дүгнэлтийн хамт Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлдэг байх.

Монголын Үндэсний музейн захирал Д.Отгонсүрэнд:

1. Угсаатан зүй, соёлын биет бус өвийн авран хамгаалах судалгааг гүйцэтгэхдээ захиалагч байгууллагын албан хүсэлтийг авч, шаардагдах зардлыг зэх зээлийн үнийн судалгаанд үндэслэн бодитой төсөвлөн, судалгааны зорилго, зорилт, арга зүй, бүрэлдэхүүн, хугацаа, хамрах хүрээ зэргийг тусгасан удирдамж, төлөвлөгөө боловсруулах, судалгааны ажлын тайлан бичих, захиалагч байгууллагад хүргүүлэх үе шатанд ЭШТ-ийн дарга, албан хаагчийн хууль тогтоомжоор хүлээсэн эрх, үүргийн хэрэгжилтэд дотоод хяналтыг тавьж ажиллах;
2. Монголын Үндэсний музейн захирлын 2025 оны 179 болон 180 дугаар албан бичгээр гаргасан дүгнэлтийг хүчингүй болгож, холбогдох төрийн байгууллага болон захиалагч Тун да шун майнинг ХХК-нд хүргүүлэн, дүгнэлтээс үүдэн гарсан эрхзүйн үр дагаврыг залруулах;
3. Эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр 3 жил ажилласан туршлагатай Г.Хос-Эрдэнийг судалгааны багийн ахлагчаар томилох асуудлыг таслан зогсоож, Соёлын сайд, БШУС-ын 2023 оны А/509, А/562 дугаар хамтарсан тушаалаар баталсан

- “Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх журам”-ын 4.1, 4.2, 4.3-д дахь заалтыг мөрдөж ажиллах;
4. Нью Жуулчин тур ХХК-тай 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан 08/2025 дугаартай музейн ваучерын үйлчилгээний гэрээний 2.1.7 дахь заалтыг мөрдөн 2026 оны эхнээс музейн үйлчилгээний төлбөрийг байгууллагын харилцах дансанд бүрэн төвлөрүүлж ажиллах, тус компаниас үйлчилгээний төлбөрийг төлөхгүй тохиолдолд гэрээг цуцлах арга хэмжээ авах;
 5. Нью Жуулчин тур ХХК-тай 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан ОУТ/SYX/250212-40 дугаартай “Аялал жуулчлалын гэрээ”-ний 5.1-д заасан 92,320.0 мянган төгрөгийн төлбөрийг хоорондын үйлчилгээний төлбөрөөс хасахаар тохирсон бартерын заалтыг цуцлан, 2025 онд суутгасан 33,260.0 мянган төгрөгийг аялал зохион байгуулсан захирлаар ажиллаж байсан Б.Сарантуяа болон аялалд хамрагдсан албан хаагчдаас гаргуулан музейн харилцах дансанд төлүүлж байгууллагыг хохиролгүй болгох;
 6. Хууль тогтоомж, тушаал шийдвэр, Албан тушаалын тодорхойлолт, Хөдөлмөрийн гэрээг мөрдөж ажиллаагүй буруутай албан тушаалтнуудад сахилгын шийтгэл ногдуулж, хариу ирүүлэх.

Монголын Үндэсний музейн Эрдэм шинжилгээний төвийн дарга Ч.Баяндэлгэрт:

1. Соёлын сайд, БШУС-ын 2023 оны А/509, А/562 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Палеонтологи, археологийн хайгуул, малтлага судалгаа хийх журам”, захирлын 2023 оны А/59 дүгээр тушаалаар баталсан “Монголын Үндэсний музейн эрдэм шинжилгээний төвийн журам” -ын дагуу угсаатан зүй, соёлын биет бус өвийн авран хамгаалах судалгааны ажлын төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шат бүрийн баримт бичгийн бүрдлийг хангаж, захиалагч талын төлбөрийг харилцах дансанд төвлөрүүлэх зэрэг арга хэмжээ авч албан тушаалын чиг үүргийн дагуу дотоод хяналтыг сайжруулах;
2. Соёлын сайд, БШУС-ын 2023 оны А/509, А/562 дугаар хамтарсан тушаалаар баталсан журмын 7.2 дахь заалтын дагуу гүйцэтгэсэн судалгааны ажлын тайланг ССАЖЗЯ-нд хүргүүлж хэвших.

Монголын Үндэсний музейн ахлах нягтлан бодогч Б.Мөнхзаяад:

1. Нью Жуулчин тур ХХК-тай 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан 08/2025 дугаартай музейн ваучерын үйлчилгээний гэрээний 2.1.7 дахь заалтыг мөрдөн 2026 оны эхнээс музейн үйлчилгээний төлбөрийг байгууллагын харилцах дансанд бүрэн төвлөрүүлж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зарцуулж, тайлагнах;
2. Угсаатан зүй, соёлын биет бус өвийн авран хамгаалах судалгааны ажлын гэрээний дагуу төлбөрийг захиалагч байгууллагаас бүрэн төлүүлж, албан томилолтын унааны түрээсийн зардлыг зах зээлийн үнийн судалгаанд үндэслэн бодитой төсөвлөх, автомашины маршрутыг баталж, шатахууны зардлыг хэмнэлттэй зарцуулахад тавих хяналтыг сайжруулах, албан томилолтын анхан шатны баримтын томилолтын хуудас, ажлын тайлангийн бүрдлийг хангуулж ажиллах.

Дотоод хяналт шалгалтын тайлан, дүгнэлтээр хүргүүлсэн авах арга хэмжээ, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн дотор яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэх.